



АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ж.БАТХӨЛӨГ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.01.23 № 01/04

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Адаацаг сумын тусгай зориулалтын сангуудад санхүүгийн аудит хийх явцад 186,617,226.00 /Нэг зуун наян зургаан сая зургаан зуун арван долоон мянга хоёр зуун хорин зургаа/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Жилийн эцсийн байдлаар нийт 186,617,226.00 төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6-д /Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах/ заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.4-т /Байгууллага, иргэдтэй үүссэн материаллаг дүнтэй буюу насжилт өндөртэй авлага, өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, насжилтын тайлан гаргах зөрчлийг давтан гаргахгүй байх;
2. Хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бууруулах, хууль, хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;

0000000008

3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 03 дугаар сарын 05-ны дотор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Адаацаг сумын Засаг дарга Ж.Батхөлөг, нягтлан бодогч Б.Энхжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

ШИНЖЭЭЧ



Ж.УГТАХБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

СУМЫН ЗАСАГ

ДАРГА



Ж.БАТХӨЛӨГ

НЯГТЛАН БОДОГЧ

Б.ЭНХЖАРГАЛ

¹ Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/